

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/139/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он</p> | <p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Аудитор: С.Сүрэнчимэг Утас: 77450279 99067036 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 8 |
| 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 10 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.24 № 106

танай _____-ны № _____-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ДАЛАНЗАДГАД СУМЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Н.ЛУВСАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5/23 дугаар тогтоолоор "Цэмцгэр Өмнөговь" ОНӨААТҮГ-ыг татан буулгаж үйл ажиллагаа болон үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө тус байгууллагад шилжсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 42,859,182.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

4626050142

F:\2.Бичиг хэрэг\2026\сн\СТА-н дүгнэлт\төсөл.Босх

Бусад асуудал хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 7 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэн 95.7 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| БАЛАНСЫН ЗҮЙЛ | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|-----------|---------------------|---------------------|
| МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 4 | - | - |
| Кассад байгаа бэлэн мөнгө | | | |
| АВЛАГА | 5 | - | - |
| УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР | | | |
| БАРАА МАТЕРИАЛ | 6 | 2,088,380,631.00 | 3,380,757,614.00 |
| Хангамжийн материал | | 2,088,380,631.00 | 3,380,757,614.00 |
| Бичиг хэргийн материал | | 437,100.00 | 2,985,848.00 |
| Аж ахуйн материал | | 282,542,271.00 | 362,219,232.00 |
| Сэлбэг хэрэгсэл | | 30,286,000.00 | 36,697,900.00 |
| Түлш, шатах тослох материал | | 6,952,600.00 | 18,954,324.00 |
| Бусад хангамжийн материал | | 1,768,162,660.00 | 2,959,900,310.00 |
| НӨӨЦИЙН БАРАА | | 862,474,860.00 | 862,474,860.00 |
| БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | | | |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 2,950,855,491.00 | 4,243,232,474.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ | | | |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7 | 147,854,511,584.13 | 170,559,966,255.38 |
| Биет хөрөнгө | | 147,233,262,184.13 | 169,936,893,522.06 |
| Барилга, байгууламж | | 4,526,298,273.29 | 6,660,742,009.29 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (784,324,396.77) | (939,871,834.69) |
| Авто- тээврийн хэрэгсэл | | 3,538,308,834.00 | 3,850,031,334.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (2,156,707,403.17) | (1,549,535,799.64) |
| Машин, тоног төхөөрөмж | | 270,832,966.00 | 1,730,856,440.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (86,292,282.74) | (621,884,088.98) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | | 98,660,954.85 | 121,497,007.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (47,687,068.49) | (57,684,866.78) |
| Зам гүүрийн байгууламж | | 160,477,050,089.36 | 173,953,460,152.36 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (72,992,246,359.93) | (85,706,967,929.76) |
| Түүх соёлын дурсгалт зүйлс | | 8,394,075.19 | 8,394,075.19 |
| Бусад үндсэн хөрөнгө | | 69,937,389,108.80 | 95,256,439,396.84 |
| Хуримтлагдсан элэгдэл | | (15,556,414,606.26) | (22,768,582,372.77) |
| БИЕТ БУС ХӨРӨНГӨ | | 770,000.00 | 2,593,333.32 |
| Программ хангамж | | 770,000.00 | 4,670,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | | | (2,076,666.68) |
| Бусад биет бус хөрөнгө | | 620,479,400.00 | 620,479,400.00 |
| БУСАД ХӨРӨНГӨ | 8 | 620,479,400.00 | 620,479,400.00 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 147,854,511,584.13 | 170,559,966,255.38 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | 150,805,367,075.13 | 174,803,198,729.38 |
| Өглөг | 9 | - | - |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | - | - |
| Урт хугацаат зээл | 10 | | |
| УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН | | | |
| НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо | | 150,805,367,075.13 | 174,803,198,729.38 |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 18,810,395,242.87 | 18,810,395,242.87 |
| Хуримтлагдсан үр дүн | | 131,903,891,002.08 | 155,901,722,656.33 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 91,080,830.18 | 91,080,830.18 |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН | | 150,805,367,075.13 | 174,803,198,729.38 |
| ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | | 150,805,367,075.13 | 174,803,198,729.38 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| | | /төгрөгөөр/ | |
|---|-----------|---------------------------|--------------------------|
| ҮЗҮҮЛЭЛТ | Тодруулга | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО | | | |
| ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 7,940,787,435.00 | 10,636,908,473.00 |
| Урсгал | | 6,713,639,900.00 | 9,185,561,400.00 |
| ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 1,201,684,535.00 | 1,179,404,673.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 25,463,000.00 | 271,942,400.00 |
| Бараа, үйлчилгээний орлого | | 50,255,367,355.99 | 44,662,941,360.30 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 12,799,727.69 | 13,524,500.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 45,355,718,207.30 | 42,859,182,710.30 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 4,886,849,421.00 | 1,232,886,650.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | | 557,347,500.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2 | 58,196,154,790.99 | 55,299,849,833.30 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | | | |
| АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ | | 5,440,850,758.87 | 7,707,464,877.52 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 4,835,377,938.49 | 6,803,973,575.60 |
| Цалин | | 2,325,697,252.70 | 2,850,691,987.07 |
| Нэмэгдэл зардал | | 1,740,297,982.09 | 2,197,559,238.59 |
| Унаа хоолны хөнгөлөлт | | 418,907,061.06 | 553,965,751.99 |
| Урамшуулал | | 350,475,642.64 | 1,201,756,597.95 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | | 605,472,820.38 | 903,491,301.92 |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл | | 410,826,832.58 | 583,778,790.68 |
| Тэтгэмжийн даатгалын шимтгэл | | 48,040,323.54 | 68,577,739.35 |
| ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | | 26,591,715.85 | 73,392,245.43 |
| Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | | 23,188,676.55 | 50,495,908.20 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | | 96,825,271.86 | 127,246,618.26 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ | | 19,030,140,536.99 | 23,594,553,301.53 |
| Тогтмол зардал | | 470,625,565.39 | 752,736,686.14 |
| Гэрэл цахилгааны зардал | | 454,918,499.26 | 725,979,577.53 |
| Түлш, халаалтын зардал | | 9,215,675.13 | 19,419,302.01 |
| Цэвэр, бохир усны зардал | | 6,491,391.00 | 7,337,806.60 |
| Үйл ажиллагааны зардал | | 17,672,984,035.40 | 22,065,758,803.05 |
| Эм | | 300,000.00 | 400,000.00 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | | 147,121,515.00 | 280,509,496.00 |
| Бичиг хэргийн материал | | 6,322,400.00 | 8,723,202.00 |
| Тээвэр, шатахууны зардал | | 497,687,022.00 | 450,113,554.00 |
| Шуудан холбооны зардал | | 2,988,704.00 | 4,677,396.00 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | | 93,419,986.00 | 96,265,362.00 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | | 40,324,600.00 | 40,413,240.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 29,978,695.00 | 67,093,894.00 |
| Урсгал засварын зардал | | 431,637,450.80 | 396,832,490.00 |
| Элэгдлийн зардал | | 16,423,203,662.60 | 20,720,730,169.05 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | | 886,530,936.20 | 776,057,812.34 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | | 427,155,285.00 | 97,106,300.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 119,700,000.00 | 88,120,945.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 339,675,651.20 | 590,830,567.34 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 3 | 24,470,991,295.86 | 31,302,018,179.05 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН III)=(I)-(II) | | 33,725,163,495.13 | 23,997,831,654.25 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО | | - | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | | - | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | | 6,188,358,722.86 | - |
| Үнэ төлбөргүй гарсан зардал -ҮХ | | 1,766,223,749.86 | |
| Үнэ төлбөргүй гарсан зардал -Бараа материал | | 4,422,134,973.00 | |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | | (6,188,358,722.86) | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | | 27,536,804,772.27 | 23,997,831,654.25 |
| Хяналтын хувь оролцоонд хамаарах үр дүн | | | |
| Хяналтын бус хувь оролцоонд хамаарах үр дүн | | | |

Өмнөговь аймгийн Даланзадгад хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| | /төгрөгөөр/ | |
|---|-------------------------|--------------------------|
| ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
| Татаас, санхүүжилтийн орлого | 6,713,639,900.00 | 9,185,561,400.00 |
| Орон нутгийн төсвөөс | 6,713,639,900.00 | 9,185,561,400.00 |
| Бараа, үйлчилгээний орлого | 1,239,947,262.69 | 1,464,871,573.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 25,463,000.00 | 271,942,400.00 |
| ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 1,201,684,535.00 | 1,179,404,673.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12,799,727.69 | 13,524,500.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 7,953,587,162.69 | 10,650,432,973.00 |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | 5,432,731,989.41 | 7,707,115,277.52 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 4,829,233,055.99 | 6,803,623,975.60 |
| Цалин | 2,319,552,370.20 | 2,850,342,387.07 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 2,509,680,685.79 | 3,953,281,588.53 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 603,498,933.42 | 903,491,301.92 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 506,673,661.56 | 776,244,682.66 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 96,825,271.86 | 127,246,619.26 |
| Бараа, үйлчилгээний урсгал зардал | 2,520,855,173.28 | 2,943,317,695.48 |
| Тогтмол зардал | 475,305,565.39 | 753,616,686.14 |
| Гэрэл цахилгааны зардал | 454,918,499.26 | 725,979,577.53 |
| Түлш, халаалтын зардал | 13,895,675.13 | 20,299,302.01 |
| Цэвэр, бохир усны зардал | 6,491,391.00 | 7,337,806.60 |
| Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал | 1,159,018,671.69 | 1,413,643,197.00 |
| Эм | 300,000.00 | 400,000.00 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 183,195,675.00 | 280,772,012.00 |
| Бичиг хэргийн материал | 6,000,000.00 | 9,704,450.00 |
| Тээвэр, шатахууны зардал | 504,639,622.00 | 462,115,278.00 |
| Шуудан холбооны зардал | 2,988,704.00 | 4,677,396.00 |
| Ном хэвлэлийн зардал | | 250,000.00 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 86,234,150.00 | 132,868,170.00 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 41,940,000.00 | 64,811,400.00 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 26,462,422.69 | 68,773,393.00 |
| Урсгал засварын зардал | 307,258,098.00 | 389,271,098.00 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | 886,530,936.20 | 776,057,812.34 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 427,155,285.00 | 97,106,300.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 119,700,000.00 | 88,120,945.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 339,675,651.20 | 590,830,567.34 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II) | 7,953,587,162.69 | 10,650,432,973.00 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(IV) | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН(V) | - | - |
| ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV) - (V) | - | - |
| САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII) | - | - |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX) = (VII) + (VIII) | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|-------------------------------------|-----------------------------|---------------------------|---------------------------|---------------------------|
| 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 18,810,395,242.87 | 91,080,830.18 | 104,367,086,229.81 | 123,268,562,302.86 |
| Залруулсан үлдэгдэл | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 27,536,804,772.27 | 27,536,804,772.27 |
| 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 18,810,395,242.87 | 91,080,830.18 | 131,903,891,002.08 | 150,805,367,075.13 |
| Залруулсан үлдэгдэл | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 23,997,831,654.25 | 23,997,831,654.25 |
| 2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 18,810,395,242.87 | 91,080,830.18 | 155,901,722,656.33 | 174,803,198,729.38 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|-------------------------|-------------------------|-------------------------|-------------|
| Татаас, санхүүжилтийн орлого | 9,377,935,000.00 | 8,624,199,199.77 | (753,735,800.23) | 91.9 |
| Орон нутгийн төсвөөс | 9,377,935,000.00 | 8,624,199,199.77 | (753,735,800.23) | 91.9 |
| Бараа, үйлчилгээний орлого | 20,000,000.00 | 13,524,500.00 | (6,475,500.00) | 67.6 |
| Туслах үйл ажиллагаанаас санхүүжих | 20,000,000.00 | 13,524,500.00 | (6,475,500.00) | 67.6 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 9,397,935,000.00 | 8,637,723,699.77 | (760,211,300.23) | 91.9 |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | 6,708,421,900.00 | 6,538,811,371.63 | (169,610,528.37) | 97.5 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 5,904,188,400.00 | 5,764,991,352.24 | (139,197,047.76) | 97.6 |
| Цалин | 2,823,424,700.00 | 2,788,672,463.53 | (34,752,236.47) | 98.8 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 3,080,763,700.00 | 2,976,318,888.71 | (104,444,811.29) | 96.6 |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | 804,233,500.00 | 773,820,019.39 | (30,413,480.61) | 96.2 |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 685,713,100.00 | 664,276,386.23 | (21,436,713.77) | 96.9 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 118,520,400.00 | 109,543,633.16 | (8,976,766.84) | 92.4 |
| Бараа, үйлчилгээний урсгал зардал | 2,669,513,100.00 | 2,098,612,328.14 | (570,900,771.86) | 78.6 |
| Тогтмол зардал | 851,200,000.00 | 753,616,686.14 | (97,583,313.86) | 88.5 |
| Гэрэл цахилгааны зардал | 811,200,000.00 | 725,979,577.53 | (85,220,422.47) | 89.5 |
| Түлш, халаалтын зардал | 23,000,000.00 | 20,299,302.01 | (2,700,697.99) | 88.3 |
| Цэвэр, бохир усны зардал | 17,000,000.00 | 7,337,806.60 | (9,662,193.40) | 43.2 |
| Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал | 1,486,837,100.00 | 1,159,768,397.00 | (327,068,703.00) | 78.0 |
| Эм | 400,000.00 | 400,000.00 | - | 100.0 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 90,000,000.00 | 64,197,212.00 | (25,802,788.00) | 71.3 |
| Бичиг хэргийн материал | 14,160,000.00 | 9,404,450.00 | (4,755,550.00) | 66.4 |
| Тээвэр, шатахууны зардал | 660,661,100.00 | 444,115,278.00 | (216,545,822.00) | 67.2 |
| Шуудан холбооны зардал | 6,000,000.00 | 4,677,396.00 | (1,322,604.00) | 77.9 |
| Ном, хэвлэлийн зардал | 8,000,000.00 | 250,000.00 | (7,750,000.00) | 3.1 |
| Жижиг эд хогшил худалдан авах зардал | 184,600,000.00 | 132,868,170.00 | (51,731,830.00) | 72.0 |
| Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал | 65,000,000.00 | 64,811,400.00 | (188,600.00) | 99.7 |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 56,216,000.00 | 49,773,393.00 | (6,442,607.00) | 88.5 |
| Урсгал засварын зардал | 401,800,000.00 | 389,271,098.00 | (12,528,902.00) | 96.9 |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | 331,476,000.00 | 185,227,245.00 | (146,248,755.00) | 55.9 |
| Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал | 97,200,000.00 | 97,106,300.00 | (93,700.00) | 99.9 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 234,276,000.00 | 88,120,945.00 | (146,155,055.00) | 37.6 |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 9,377,935,000.00 | 8,637,423,699.77 | (740,511,300.23) | 92.1 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | - | - |

**Өмнөговь аймгийн Даланзадгад хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | |
|---|--|---|--|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | |
|---|--|---|--|

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|------------|-------------------------|---------------------------|
| Татаас, санхүүжилтийн орлого | | 1,451,347,073.00 | (1,451,347,073.00) |
| ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 1,179,404,673.00 | (1,179,404,673.00) |
| Бараа, үйлчилгээний орлого | | | - |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 271,942,400.00 | (271,942,400.00) |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | | 1,451,347,073.00 | (1,451,347,073.00) |
| Ажиллагчидтай холбогдсон зардал | | 1,168,303,905.89 | (1,168,303,905.89) |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,038,632,623.36 | (1,038,632,623.36) |
| Цалин | | 61,669,923.54 | (61,669,923.54) |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | | 976,962,699.82 | (976,962,699.82) |
| Нийгмийн хамгааллын шимтгэл | | 129,671,282.53 | (129,671,282.53) |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | | 111,968,297.53 | (111,968,297.53) |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | | 17,702,985.00 | (17,702,985.00) |
| Бараа, үйлчилгээний урсгал зардал | | 283,043,167.11 | (283,043,167.11) |
| Тогтмол зардал | | - | - |
| Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал | | 253,574,800.00 | (253,574,800.00) |
| Бусад бараа үйлчилгээний зардал | | 216,574,800.00 | (216,574,800.00) |
| Тээвэр, шатахууны зардал | | 18,000,000.00 | (18,000,000.00) |
| Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 19,000,000.00 | (19,000,000.00) |
| Хөтөлбөр арга хэмжээний зардал | | 29,468,367.11 | (29,468,367.11) |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | 29,468,367.11 | (29,468,367.11) |
| НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | | 1,451,347,073.00 | (1,451,347,073.00) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | - |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,493.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,493.3 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Ерөнхий журналын цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардалтай тулгахад түлш, шатах материалын данснаас үндсэн цалингийн зардалд 753.0 мянган төгрөгийн бичилт хийж, цалингийн зардлыг нэмэгдүүлсэн алдаа нь , УСНББОУС-12 Бараа материал, УСНББОУС-1 Топилуулга стандартын заалт, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг;
- Санхүүгийн тайлангаарх бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл бараа материалын тодруулга тайлангийн үлдэгдлээс 1,740.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа алдаа нь УСНББОУС-12 Бараа материал стандартын заалт, Топилуулга батламж мэдэгдлийг тус тус хангахгүй,
- Санхүүгийн тайлан, тодруулгыг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын 2-р хавсралт "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу батлагдсан маягтаар бэлтгээгүй байна. Энэ нь УСНББОУС-1 Топилуулга стандартын заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2 дугаар зүйлийн 20.2.-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Үүнээс | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
|---|---|------------|----------------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|--|-----|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Ерөнхий журналын цалингийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардалтай тулгахад түлш, шатах материалын данснаас үндсэн цалингийн зардалд 753.0 мянган төгрөгийн бичилт хийж, цалингийн зардлыг нэмэгдүүлсэн | 1 | 753.0 | | | | | | | | | | |
| 2 | Санхүүгийн тайлангаарх бусад хангамжийн материал дансны эхний үлдэгдэл бараа материалын тодруулга тайлангийн үлдэгдлээс 1,740.2 мянган төгрөгөөр зөрүүтэй | 1 | 1,740.2 | | | | | | | | | | |
| 3 | Санхүүгийн тайлан, тодруулгыг Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын 2-р хавсралт "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу батлагдсан маягтаар бэлтгээгүй | 1 | 0.0 | | | | | | | | | | |
| | Дүн | 3 | 2,493.2 | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|--|-------------|-----------------|-----------------|-----------------|---------|-----|
| | | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| 1 | Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 гүйлгээ буюу 16,270.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна, мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулбал зохих 2 мэдээлэл буюу 52,475.0 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй байна.. | 1 | 68,745.0 | 1 | 68,745.0 | | |
| | Дүн | 1 | 68,745.0 | 1 | 68,745.0 | | |